



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/04

Ховд

Албан тушаалын тодорхойлолт батлах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Нутгийн удирдлагын ордны үйлчилгээний тасгийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Санхүү, аж ахуйн тасгийн нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, няравын албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, механик жолоочийн албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, жолоочийн албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Нутгийн удирдлагын ордны үйлчилгээний тасгийн үйлчлэгчийн албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, албан тушаалын тодорхойлолтыг мөрдүүлж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга /Б.Ганболд/- д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД